



**“УЛААНБААТАР БҮК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022.02.15

№2022/ 03

Улаанбаатар хот

Г “Ногдол ашиг хуваарилах тухай” Г

“Компанийн тухай” хуулийн 46, 47 дугаар зүйл, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Улаанбаатар БҮК” ХК-ийн 2021 оны цэвэр ашгаас нийт 1,315,475,000 /нэг тэрбум гурван зуун арван таван сая дөрвөн зуун далан таван мянган/ төгрөгийг нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилахыг зөвшөөрсүгэй.

2. Нэгж хувьцаанд 10,0 /арван/ төгрөгийн ашиг тараахыг Гүйцэтгэх захирал /Х.Золжаргал/ -д үүрэг болгосугай.

3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.

4. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд 2022 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар дамжуулан тарааж эхэлсүгэй.

5. Энэхүү тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Х.Золжаргал/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Д.НЯМХҮҮ



“Улаанбаатар БУК” ХК-ийн ТУЗ-ийн №..... тоот тогтоолын хавсралт



“УЛААНБААТАР БУК” ХК-ИЙН НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХААР
ШИЙДВЭРЛЭСЭН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийн огноо дугаар	Аль оны ногдол ашиг болох	Нэгж хувьцаанд олгохоор шийдвэрлэсэн ногдол ашгийн хэмжээ	Ногдол ашгийн олгож эхлэхээр товлосон хугацаа	Ногдол ашгийг олгох хэлбэр /мөнгө, эд хөрөнгө, үнэт цаас/	Ногдол ашгийг хаана олгох /компани дээр, “ҮЦТХТ” ХХК/
2022 оны 2 дугаар сарын 15-ний өдрийн тоот ТУЗ-ийн тогтоол	2021 оны жилийн эцсийн ногдол ашиг	10,0 төгрөг	2022-6-01	Мөнгөн хэлбэрээр	“ҮЦТХТ” ХХК

Мэдээлэл бэлтгэсэн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Д.Байгальмаа/

Мэдээллийг хянасан ТУЗ-ийн дарга : /Д.Нямхүү/

